**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 19-өдөр Дугаар А/581 Булган сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 33 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн Баян-Агт сумын /Шарга/ 1 дүгээр багийн Дун шарга болон /Дулаан хаан/ 4 дүгээр багийн Жаргалант гэх газар, Сайхан сумын 6 дугаар багийн Дан гэх газар, Хутаг-Өндөр сумын /Уньт/ 3 дугаар багийн Их дабааны гарам гэх газруудад мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчин оношлогдож, батлагдсантай холбогдуулан 2022 оны 09 сарын 19-ний өдрөөс тухайн нутаг дэвсгэрт тодорхойгүй хугацаагаар “хорио цээрийн дэглэм” тогтоосугай.

2.Хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт “Шуурхай бүлэг” томилон тандалт судалгааны ажлыг эрчимтэй зохион байгуулж, удирдлага зохицуулалтаар ханган, хариу арга хэмжээг төлөвлөгөөний дагуу авч ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр сумын Засаг дарга нарт, дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж хамтран ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Тагнуулын хэлтэс (хурандаа Б.Жавхлантөгс), Мэргэжлийн хяналтын газар (Б.Батболд) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Өвчний сэжиг илэрсэн бүс нутаг, мал сүрэгт үзлэг тандалт хийж, бүсийг тогтоон голомт, сэжигтэй бүсээс гадагш хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн зөөвөрлөхийг хязгаарлан хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Б.Батболд), Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр сумын Засаг дарга нарт даалгасугай.

4.Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс холбогдох хууль, эрх зүйн хүрээнд тухай бүр шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/ Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган, үүрэг чиглэл өгч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ш.Баасандорж), аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Д.Алтаншагай) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

6322010727